

## БИЧИЛ УУРХАЙН НӨХӨРЛӨЛТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

2017-08-10.

Дугаар-06

Дархан

Монгол улсын Газрын тухай хуулийн 16.1.11 дэх заалт, Засгийн газрын 2010 оны 308-р тогтоолын 8.1, 8.2 дах заалт, Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05-р сарын 10-ны 35 тоот тогтоолын дагуу нэг талаас Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг дарга **Нацаг** овогтой **Эрхэмбаяр** (цаашид "Засаг дарга" гэх), нөгөө талаас бичил уурхайн "**Хангай**" нэртэй бүртгэгдээгүй нөхөрлөл (цаашид "Нөхөрлөл" гэх)-ийг төлөөлж нөхөрлөлийн ахлагч **Ёндон** овогтой **Болдхуяг** нар харилцан тохиролцож энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г байгуулав.

### **Нэг. Ерөнхий зүйл**

Нөхөрлөл нь Булган аймгийн Бүрэгхангай сумын Дэрст багийн "Тосон" нэртэй газарт орших 3,96 гектар /га/ талбайн өөрт ногдох 3,0 гектар /га/ талбайд гэрээнд заасан хугацаагаар алт олборлох үйл ажиллагаа эрхлэнэ. Солбилцол:

№	Уртраг			Өргөрөг		
	град	мин	сек	град	мин	сек
1	104	32	28,5	48	27	27
2	104	32	16	48	27	27
3	104	32	16	48	27	32
4	104	32	28,8	48	27	32

2. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар сумын Засаг дарга, нөхөрлөлийн хооронд үүсэх харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

### **Хоёр. Сумын Засаг даргын эрх, үүрэг**

2.1. Сумын Засаг дарга дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

2.1.1 "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3-т заасан үүрэг хүлээнэ.

2.1.2 Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээг тогтоож, талбайн байршлын зургийг гэрээнд хавсаргах;

2.1.3. Нөхөрлөлийн гишүүдийн амьдрах суурьшлын бүс болон хог хаягдлын цалин байршлыг тогтоож өгөх;

2.1.4 Олборлолт явуулсан талбайг буцаан хүлээлгэж өгөхийн амна, хийх нөхөн сэргээлтийн зааврыг нөхөрлөлд танилцуулж ойлголцсон байх;

Бүртгэлийн дугаар: .....

**ХУУЛБАР**

Хуульч олгосон гэрээний үндсэн үсэг

19 04 08

2.1.5. Нөхөрлөлд ногдох талбайн хэмжээтэй уялдуулан олборлолт явуулсан талбайд хийх техникийн нөхөн сэргээлтийн ажлын зардлыг тооцож, нөхөн сэргээлтийн дундын санд төвлөрүүлэх мөнгөний хэмжээ, хугацааг нөхөрлөлтэй харилцан тохиролцож зохих хөрөнгийг төвлөрүүлэх;

2.1.6. "Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм"-ийг дагаж мөрдөж байгаа эсэх, ажлын байрны зааварчлага өгөх үүргээ нөхөрлөлийн ахлагч биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

2.1.7. Гишүүдийг хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны арга барилд сургах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах;

2.1.8. Нөхөрлөлийн олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдах үйл ажиллагаанд хяналт тавих, олборлолтын мэдээ хөтлүүлэх;

2.1.9. Нөхөрлөлийн гишүүдэд эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдолыг тайлбарлан таниулах ажлыг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалд хамруулах.

2.1.10. Нөхөрлөлөөс талбайг буцааж хүлээлгэж өгөхийн өмнө хийсэн нөхөн сэргээлтийн ажлыг газар дээр нь байгаль орчны хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулан, комисс томилж хүлээж авах;

2.1.11. Нөхөрлөлд ашигт малтмал олборлох талбай дахин олгох асуудлыг шийдвэрлэх;

2.1.12. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбай дээр нөхөрлөлийн гишүүн бус этгээд ажиллаж буй эсэхэд хяналт тавих;

2.1.13. Нөхөрлөлийн гишүүдэд бичил уурхай эрхлэгчийн хувьд хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргийг нь тайлбарлан таниулж, татварын үүрэг биелүүлэхтэй нь холбогдсон сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах;

2.2. Засаг дарга дараах эрхтэй. Үүнд:

2.2.1. "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын 3-т заасан эрх эдэлнэ:

2.2.2. Нөхөрлөлд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.2.3. Нөхөрлөлийн ахлагчид үүрэг даалгавар өгөх, гүйцэтгэлийг шалгах;

2.2.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй, ашигласан талбайн нөхөн сэргээлт хийгээгүй нөхөрлөлийн ашигт малтмал олборлох үйл ажиллагааг түр зогсоож, хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцох, гэрээг цуцлах;

2.2.5. Хүн, мал, байгаль орчинд харш үйл ажиллагааг зогсоох;

## Гурав. Нөхөрлөлийн эрх, үүрэг

3.1. Нөхөрлөл дараах үүрэгтэй. Үүнд:

3.1.1. Нөхөрлөлийн гишүүдийг тогтоосон бүсэд суурьшуулах;

3.1.2. Нөхөрлөл нь гэрээнд заасан талбайн хил, хязгаарын дотор үйл ажиллагаа явуулах;

3.1.3. Байгаль орчныг хамгаалах, гол ус, булаг шанд, уст цэгүүдийг хамгаалахгүйгээр зүй зохистой хэрэглэх;

3.1.4. Орчны тохижилт хийх, хог, хаягдлын цэгийг байгуулах, хог хаягдлын байгуулах;

3.1.5. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж гөрдөх, осол аваараас урьдчилан сэргийлэх арга техникт суралцах;

3.1.6. Ашигт малтмалыг баяжуулах, ялгаж ангилах үйл ажиллагааг өөрийн тусгай байгуулсан талбайд байрлах тогтоосон зориулалтын цэг талбайд гүйцэтгэх;

3.1.7. Байгаль орчныг нөхөн сэргээх талаар хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй. Болгож сумын Засаг даргын тогтоосон байгаль орчны нөхөн сэргээлтийн үүрэгтэй шаардагдах төгрөгийг га тутамд 5.000.000 /Таван сая/ тооцож Байгаль орчныг хамгаалах санд төвлөрүүлэх;

3.1.8. Байгаль хамгаалах санд төвлөрүүлсэн мөнгийг нөхөрлөл нөхөн сэргээх хийсний дараа БОХУБ-ын дүгнэлтийг үндэслэн буцааж олгоно.

3.1.9. Талбааг хүлээлгэн өгөхийн өмнө нөхөн сэргээлт хийж сумын байгаль орчныг хамгаалалтын үлсын байцаагчаар дүгнэлт гаргуулан, сумын Засаг даргын тогтоосон комисст хүлээлгэн өгөх;

3.1.10. Олборлосон ашигт малтмалыг хууль тогтоомжийн дагуу худалдан авалтын үйлдлийн хуулийн этгээдэд худалдана;

3.1.11. Бичил уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны нөхөн сэргээлт хийхэд чиглэгдсэн сургалт, сурталчилгаанд оролцох үүрэгтэй идэвхитэй оролцуулах;

3.1.12. Холбогдох хууль тогтоомжийн дагуу бичил уурхай эрхлэгч иргэн бүр жилд нэг бүр 20000 /Хорин мянган/ төгрөг төлөх;

3.1.13. Хууль ёс нийгмийн хэв журмыг зөрчсөн адиваа үйлдэлтэй хамт мөрдөх үүрэгтэй байх.

Энэхүү хууль тогтоомжийн дагуу ажиглагчид хиймийн хорт болон аюултай бодис ашиглахгүй байх, тусгай зөвшөөрөлтэй этгээдээр гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд тэсэрч ашиглах бодис, тэсэлгээний хэрэгсэлийг ашиглахгүй байх;

**ХУУЛЬБАР**

Хуульбар олгосон ажиглагчийн гарын үсэг

2008 оны 04 сарын 08-ны өдөр

3.1.15. Нөхөрлөлд гэрээгээр олгосон талбайд зөвхөн нөхөрлөл-  
гишүүнийг ажиллуулах;

3.1.16. Ашигт малтмал олборлолтын үйл ажиллагаанд  $3500 \text{ см}^3$  —ээс дээш  
баггаамжтай дотоод шаталтат хөдөлгүүр бүхий механизмыг ашиглахгүй байх.

3.1.17. Гэрээгээр олгосон талбайг өөр иргэн, ААН-д өгөхгүй байх.

3.2. Нөхөрлөл дараах эрхтэй. Үүнд:

3.2.1. Нөхөрлөлд олгосон талбайд ашигт малтмал олборлох  
ажиллагаагаа явуулах;

3.2.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх болон нийгэм  
асуудлыг шийдвэрлэх, бичил уурхайн бүтэц, зохион байгуулалт, техник  
сайжруулахтай холбогдсон санал, санаачлага гаргах;

3.2.3. Нөхөн сэргээлт хийсэн талбайг хүлээлгэн өгсөний дараа дахин а.  
малтмал олборлох гэрээ байгуулах өргөдөл гаргах;

3.2.4. Нөхөрлөл нь үйл ажиллагаа явуулахдаа шаардлагатай мэргэжил  
ажиллуулах, зөвлөгөө туслалцаа авах, нөхөн сэргээлтэнд өндөр хүчин ч.  
техник ашиглах, иргэн, ААН-тэй хамтран ажиллах гэрээ байгуулах.

#### **Дөрөв. Харилцан хүлээх үүрэг**

4.1. Гэрээнд оролцогч талууд харилцан хүндэтгэх зарчим дээр тулгуур  
хамтарч ажиллана.

4.2. Гэрээний дагуу олборлолт явуулж байгаа нөхөрлөлийн буруутай  
ажиллагаанаас шалтгаалан байгаль орчин, хүн малд хохирол учирвал нөхөрлөл  
хохирлыг барагдуулах үүрэг хүлээх ба Засаг дарга тухайн нөхөрлөлийн  
хохирлыг барагдуулахыг шаардах үүрэгтэй.

#### **Тав. Маргаан шийдвэрлэх**

5.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар  
шийдвэрлэнэ.

5.2. Талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль  
тогтоомжийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

Бүртгэлийн дугаар: .....
<b>ХУУЛБАР</b>
Хуулбар олгосон ажлын үсэг
<i>[Signature]</i>
19 04 08

### Зургаа. Гэрээний үйлчлэх хугацаа

6.1. Энэхүү гэрээ нь 2017 оны 08 сарын 10-ны өдрөөс 2017 оны 11 сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ. Талууд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс эхлэн гэрээ хүчин төгөлдөр болно.

6.2. Бичил уурхайн нөхөрлөл гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд цаашид нэг удаа гэрээг сунгаж ажиллана.

6.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлосон талбайд нөхөн сэргээлт хийж орон нутагт хүлээлгэж өгснөөр энэхүү гэрээний үүрэг дуусгавар болно.


6.4. Гэрээний хавсралтууд нь түүний салшгүй хэсэг байна.

6.5. Гэрээг 2 хувь үйлдэж талууд тус бүр нэг хувийг хадгална.

### Гэрээ байгуулсан:

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ

ДАРГА:




/Н.ЭРХЭМБАЯР/

Хаяг: Булган аймгийн Бүрэгхангай сумын 4-р баг Дархан, ЗДТГ.

Утас: 94003133, 80093133.

e-mail: n.erkhembayar99@gmail.com

"ХАНГАЙ" НӨХӨРЛӨЛИЙН АХЛАГЧ:



/Ё.БОЛДХУЯГ/

Хаяг: Булган Бүрэгхангай 4-р баг Дархан.

Утас: 94849611, 98609611.

e-mail: .....

Бүртгэлийн дугаар: .....

**ХУУЛБАР**

Хуулбар олгосон ажлын гарын үсэг

19 04 08-ны өдөр